

## Мобайл банкны цэсийг гар утсандаа суулгах

Мобайл банк нь үүрэн телефоны оператор болох Мобикомын хэрэглэгчдын гар утаснаас ажиллах ба тухайн гар утас нь интернетийн тохиргоотой байх, мөн Жава дэмждэг (Java supported) байх шаардлагатай.

## Мобайл банкны үндсэн цэс


[Гүйлгээ](#)  
[Үлдэгдэл](#)  
[Хуулга](#)  
[Мэдээлэл](#)  
[Тохиргоо](#)


### Гүйлгээ

Гүйлгээ нь дараах 2 төрлийн гүйлгээг хийх боломжтой.

#### **Банк дотор** **Банк хооронд**

- 1. Банк дотор**

Хүлээн авах данс	Энэ данс нь өөрийн банкны данс байна. Өөр буруу данс оруулбал шалгана.
Валют (хүлээн авах дансны)	Хүлээн авагч дансны валютаа оруулна. Валютын дугаарын оруулна.
Дүн (хүлээн авах дансны валютаар)	Шилжүүлэх гэж буй мөнгөн дүнг оруулна.  Хэрэв төгрөгийн данснаас долларын дансруу шилжүүлэх гэж байгаа бол мөнгөн дүнг оруулахдаа долларын дүнгээр тооцож оруула.
Гүйлгээний утга	Шилжүүлэх гэж буй гүйлгээний утгыг оруулна.
Хүлээн авагчийн нэр	Шилжүүлэг хүлээн авах гэж байгаа дансны эзний нэрийг оруулна.
Гүйлгээний нууц үг	Харилцагч өөрийхөө бүртгүүлсэн гүйлгээний нууц үгээ оруулна.
- 2. Банк хооронд**

Хүлээн авах банкны дугаар	Явуулах гэж буй данс аль банкны данс вэ? Тэр банкныхаа дугаарыг оруулна. Банкны дугаараа лавлахдаа <b>Мэдээлэл \ Банк</b> гэж лавлана. Банк болгон өөрийн гэсэн дугаартай байгаа. Бүх банкны дугаарыг оруулсан байгаа.
Хүлээн авах данс	Хүлээн авагчийн дансаа оруулна. Манай банкны данс биш учраас энэ дансыг зөв оруулах хэрэгтэй.
Валют (хүлээн авах дансны)	Хүлээн авагч дансны валютаа оруулна. Валютын дугаарын оруулна.
Дүн (хүлээн авах дансны валютаар)	Шилжүүлэх гэж буй мөнгөн дүнг оруулна.  Хэрэв төгрөгийн данснаас долларын дансруу шилжүүлэх гэж байгаа бол мөнгөн дүнг оруулахдаа долларын дүнгээр тооцож оруула.
Гүйлгээний утга	Шилжүүлэх гэж буй гүйлгээний утгыг оруулна.
Хүлээн авагчийн нэр	Шилжүүлэг хүлээн авах гэж байгаа дансны эзний нэрийг оруулна.
Гүйлгээний нууц үг	Харилцагч өөрийхөө бүртгүүлсэн гүйлгээний нууц үгээ оруулна.

## Үлдэгдэл

Харилцагчийн үндсэн дансны үлдэгдлийг харуулна. Үндсэн дансыг харилцагч бүртгэхэд харилцагчийн өөрийн данснаас сонгож бүртгэнэ. Харилцагч өөр дээрээ нэгээс олон данстай бол солих боломжтой ба “Тохиргоо” цэсний “Үндсэн данс” хэсэгт харилцагч өөрөө үндсэн дансаа солих боломжтой.

## Хуулга

Хуулга харах тоог харилцагчийн бүртгэл дээр “Харах гүйлгээний тоо” гэсэн талбарт оруулж өгнө. Мөн Админ дээр системийн тоог оруулна. Энэ нь юу гэсэн үг юэ гэхээр харилцагч өөр дээрээ **Тохиргоо \ Харах тоо** гэсэн талбарт 10 гэж оруулсан гэж бодоё, гэтэл анх бүртгэсэн теллер 8 гэж оруулсан, харин админ дээр 5 гэж оруулсан бол харилцагч сүүлийн 5-н гүйлгээг л харах боломжтой гэсэн үг.

Энд дансны хуулгыг хоёр янзаар авч болно.

<u>Дансны хуулга</u>	Хамгийн сүүлийн X гүйлгээний мэдээллийг харуулна. Харах тоог урьдчилан тохируулсан бна. Дээр тайлбарласан.
<u>Имэйл-р авах</u>	Эхлэх болон дуусах огнооны интервал-г оруулахад виртуал харилцагч дээр бүртгэлтэй имэйл хаяг руу тухайн хугацаанд хийгдсэн гүйлгээний жагсаалт, дансны үлдэгдлийг явуулна.

## Мэдээлэл

Мобайл банкаар гүйлгээ хийхэд хэрэгцээтэй мэдээллүүдийг эндээс авч болно.

Дансны дэлгэрэнгүй	Энэ хэсэгт харилцагч дээр байгаа Виртуал банкинд ашиглахаар бүртгүүлсэн бүх дансд харагдах ба хамгийн эхний сонголтоор мобайл банкны үндсэн дансыг сонгосон бна. Харилцагч бүх дансныхаа дэлгэрэнгүй мэдээллийг харах боломжтой.
Лавлагаа	Энд харуулах мэдээллийг Админ програмын <b>Мэдээлэл   Мобайл мэдээлэл</b> хэсэгт ALL гэсэн индексстэйгээр тохируулж өгнө.
Банк	Банкны дугааруудыг лавлана. Банк хоорондох гүйлгээнд ашиглагдана.
Салбар	Өөрийн банкны салбарыг лавлана.
Валютын ханш	Валютын дугаарыг оруулж ханш харна. USD, MNT ...
Бусад мэдээлэл	Индекс оруулж банкнаас өгч буй мэдээллийг лавлах боломжтой. Энд оруулах индексийг Админ програмын <b>Мэдээлэл   Мобайл мэдээлэл</b> хэсэгт бүртгэнэ.

## Тохиргоо

Дансны жагсаалт	Виртуал банкинд ашиглахаар бүртгүүлсэн бүх дансд харагдах ба хамгийн эхний сонголтоор мобайл банкны үндсэн дансыг сонгосон бна.
Үндсэн данс	Мобайл банкны үндсэн дансаар сонгосон дансыг харуулах ба энэ данс нь гүйгээ хийхэд ашиглагдах данс юм.
Харах тоо	Сүүлийн хэдэн гүйлгээг харах вэ гэсэн тохируулга. Харилцагч өөрөө тохируулах боломжтой. Гэхдээ энэ харах тоо нь ГрэйпБанкны мобайлын бүртгэл дээрх харах гүйлгээний тоо гэсэн хэсэгтээ тохируулсанаас их оруулсан тохиолдолд ГрэйпБанк дээр бүртгэсэн бүртгэлээрээ л харуулах болно гэсэн үг. Мөн хамгийн том эрхтэй нь Админ програмын <b>Параметр   Ерөнхий тохиргоо</b> – Системийн хуулга харах максимум тоо хэсэгт тохируулсан хязгаарт байна.
Гүйлгээний нууц үг	Анх бүртгүүлэхэд өгсөн нууц үгийг өөрчилнө. Ингэхийн тулд хуучин нууц үгээ мэдэж байх шаардлагатай.
Нэвтрэх нууц үг	Анх бүртгүүлэхэд өгсөн нууц үгийг өөрчилнө. Энэ нууц үгийг тодорхой давтамжтайгаар өөрчилж байх хэрэгтэй.

Жишээ нь:

Та бүхэн гар утаснаасаа 202.131.228.170/mbankjava гэсэн хаягаар орж mobile банкны инсталлыг суулгах хэрэгтэй.

Холболтын тохиргоо

IP хаяг  
202.131.228.170

Порт  
9081

Хүсэлт хвлээх хугацаа /сек/  
30

Хэл  
 Монгол

Options Edit Буцах

Системд нэвтрэх

Харилцагчийн дугаар

Нууц үг

Options Edit Гаргах

Системд нэвтрэх

Харилцагчийн дугаар

Нууц үг

**Нэвтрэх**

Тохиргоо

Options Edit Гаргах

Үндсэн цэс

**Гүйлгээ**

- Үлдэгдэл
- Хуулга
- Мэдээлэл
- Тохиргоо

Select Гаргах

Гүйлгээ

**Банк дотроо**

- Банк хооронд
- Картын гүйлгээ
- ММ данс цэнэглэ

Select Гаргах

Mobile Bank

Таны дансны  
Үлдэгдэл: 800,800.88  
MNT.

Close

Хуулга

Хуулга харах

И-мэйл-р авах

Select Гаргах

Мэдээлэл

**Дэлгэрэнгүй**

- Дэлгэрэнгүй
- Лавлагаа
- Банк
- Салбар
- Валютын ханш
- Бусад мэдээлэл

Select Гаргах

Тохиргоо

**Дансны жагсаалт**

- Дансны жагсаалт
- Үндсэн данс
- Харах тоо
- Гүйлгээний нууц
- Нэвтрэх нууц үг

Select Гаргах

## Үйлчилгээ авахад ирэх хариу мэдээлэл

1. Гүйлгээний нууц код буруу байна. (харилцагчийн нууц код буруу үед ирнэ.)
2. Холбогдох эрх хаагдсан бна. (нууц кодоо 3 удаа буруу оруулсан тохиолдолд ирнэ.)
3. Та тохиргоо цэсний данс солихоор орж дансны кодоо оруулан тухайн дансаа идэвхжүүлнэ үү. (дансны кодоо буруу оруулсан тохиолдолд өгнө. Идэвхтэй дансаа лавлах хэрэгтэй.)
4. Энэ дансан дээр гүйлгээ хийх эрхгүй байна. (Гүйлгээ хийх эрхгүй ба зээлийн данснаас гүйлгээ хийх үед ирнэ.)
5. Индексийг буруу оруулсан байна. (Мэдээлэл авахдаа харгалзах индексийг буруу оруулсан үед ирнэ.)
6. Энэ бүртгэгдээгүй төлбөр байна. (төлбөр цэсийг сонгох бол бүртгүүлээгүй тохиолдолд гарна.)
7. Вальютын код буруу байна. (Шилжүүлж буй дансныхаа вальютын кодыг буруу оруулсан үед ирнэ.)
8. Банкны түвшинд тохируулсан хэмжээнээс хэтэрч байна. (Нэг удаагын гүйлгээний дээд хязгаарыг тохируулсан хэмжээнээс хэтэрсэн үед ирнэ.)
9. Дансны үлдэгдэл хүрэлцэхгүй байна. (дансны үлдэгдэл нь хүрэлцэхгүй болсон үед ирнэ.)
10. Хуучин нууц үг буруу байна. (Нууц үг солихдоо хуучин нууц үгээ буруу оруулсан тохиолдолд ирнэ.)
11. Бүртгэгдээгүй утас байна. (Мобайл банкинд бүртгүүлээгүй харилцагчид ирнэ.)